

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2024 оны 12 дугаар сарын 19

Зорилт	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Хариуцах нэгж	Биелэлт, хувь
1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх	-Тогтмол шинэчлэн, байршуулсан тогтвортой байршуулсан байх; - Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх; - Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших; - Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.	I-IV улиралд	Контентуудыг сар бүр шинэчлэн байршуулсан байна.	Ж.Үүрийнтуяа О.Ууганжаргал	Авлигатай тэмцэх газрын албан ёсны цахим хуудас болон пейж хуудсуудаар мэдээлэгдэж байгаа соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, мэдээллийг дүүргийн www.sbd.gov.mn вэб сайт, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нээлттэй Сүхбаатар, Түмэнд түгээнэ, Хуулиа дээдлэгч Сүхбаатарчууд Нийслэл Улаанбаатар болон 20 хорооны пейж хуудсуудаар олон нийтэд сурталчлан ажилласан. Тайлант хугацаанд нийтдээ 17 төрлийн видео контентыг тус бүр 3 удаагийн давталттайгаар нийтэллээ. Олон нийт иргэдэд хүрсэн тоон мэдээг агуулга давхардсан байдлаар үзүүлэлтийг гаргавал 1847 удаа түгээж, 8592 иргэн үзсэн байна. Засаг даргын Тамгын газрын хэлтэс тус бүрийн мэдээллийн самбар болон Нэг цонхны үйлчилгээний танхим, 1-20 дугаар хорооны мэдээллийн самбаруудад 10 нэр төрлийн 1511 ширхэг тараах материалыг байршуулж, мөн албан хаагчдад болон иргэдэд тараасан. 100 хувь
	1.2. Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг,	- Өдөрлөг оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх;	III улиралд	Нээлттэй хаалганы өдөрлөгийг 1 удаа зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийн мөрөөр арга хэмжээ	Б.Должинсүрэн Р.Цолмонгэрэл	Дүүргийн Засаг дарга болон хэлтэс, албадын 4 удирдах албан тушаалтны бүрэлдэхүүнтэй баг 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн батлагдсан хуваарийн дагуу хороодод

	<p>арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>- Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; - Үр дүнг тооцсон байх.</p>	<p>II, III улиралд</p>	<p>авч хэрэгжүүлсэн байна.</p>	<p>ажиллаж, 2020-2024 онд дүүргийн төсвөөр хийж хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний талаарх болон хороо тус бүрийн нутаг дэвсгэрт хийгдэж байгаа тохижилт, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын талаар мэдээлэл өгсөн. Дүүргийн 1-20 дугаар хорооны нийт 1574 иргэнтэй уулзалт хийж, амаар-133, бичгээр-261 иргэний санал хүсэлтийг хүлээн авч холбогдох хэлтэс, нэгжүүдтэй хамтран шийдвэрлэж ажиллалаа. 100 хувь</p>
<p>1.3. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэл 110 дугаарыг оруулан сурталчлах</p>	<p>- Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх; - Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; - Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх; - Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.</p>	<p>III мэдээллийг 1-2 удаа хэвлэмэл материалд оруулж, олон нийтэд түгээсэн байна.</p>	<p>Ж.Үүрийнтуяа О.Ууганжаргал Т.Төрболд</p>	<p>Байгууллагаас ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал бэлтгэн гаргадаггүй тул АТГ-аас ирүүлсэн хэвлэмэл материалыг тухай бүр олон нийтэд тараан хүргэж, хэлтэс албадын болон хороодын зар, мэдээллийн самбарт байршуулан ажилласан. 90 хувь</p>	
<p>1.4. Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх</p>	<p>- Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх; - Авлигын мэдээлэл 110 дугаарын утсыг сурталчилсан байх; - Олон нийтэд түгээсэн байх.</p>	<p>2-оос доошгүй видео контентийг бүтээж, олон нийтэд хүргэсэн байна.</p>	<p>Ж.Үүрийнтуяа О.Ууганжаргал</p>	<p>Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх 4 хэлтэс, алба, Тамгын газрын 4 хэлтсийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхыг уриалсан агуулга бүхий 8 видео контент бүтээж, олон нийтэд цуврал болгон хүргэж байна. Цуврал видео контентуудыг 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 10-ны өдрийн хугацаанд "Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар", "Нээлттэй Сүхбаатар" "Сүхбаатар дүүргийн Шуурхай штаб", "Түмэнд түгээнэ", "Нийслэл</p>	

<p>2. Ил тод байдлыг сайжруулах, суртал, бууруулах, нийтийн хэрэгжүүлэх</p>	<p>2.1. "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх;</p>	<p>- Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх;  - Сонгосон чиглэлд олон нийтийг хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх;  - Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах;  - Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх.</p>	<p>III улиралд</p>	<p>Журмын хэрэгжилтийг хангасан байна.</p>	<p>М.Очмаа Р.Цолмонгэрэл</p>	<p>Улаанбаатар" 20 хороо тус бүрийн пейжүүдээр сурталчлан, агуулга давхардсан байдлаар 1074 удаа түгээж, 7569 иргэн үзсэн байна. 100 хувь</p> <p>2.1.2 Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал:</p> <p>1. shilefans.gov.mn цахим хуудсанд сар бүрийн 08-ны өдрийн дотор дүүргийн Засаг даргын А захирамж 258, засаг даргын Тамгын газрын даргын А тушаал 163 нийт 421 захирамжлалын баримт бичгийг хугацаанд нь байршуулж ажилласан.</p> <p>2. Нийслэлийн мэдээллийн нэгдсэн сан <a href="http://iblegal.ulaanbaatar.mn">iblegal.ulaanbaatar.mn</a> сайт, дүүргийн <a href="http://sbd.gov.mn">sbd.gov.mn</a> вэб цэсэнд дүүргийн Засаг даргын А захирамж 91, Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал 38 нийт 129 захирамжлалын баримт бичгийг байршуулсан.</p> <p>2.1.3 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34 дүгээр зүйл Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах:</p> <p>Дүүргийн Засаг даргын 2024 оны Б/05 дугаар захирамжаар 20 хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий 100 олон нийтийн байцаагч томилогдсон. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 12 дугаар тогтоолоор Улсын хэмжээнд мөрдөгдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 660,000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосны дагуу дүүргийн Засаг даргын захирамжаар сар бүр</p>
---	---	---	--------------------	--	----------------------------------	---

	<p>2.2. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх</p>	<p>- Салбарт бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гэргасан байх;  - Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх;  - Үр дүнг тооцож, тайлагнасан байх</p>	<p>II, III улиралд</p>	<p>Иргэний нийгмийн байгууллагуудын судалгааг гаргаж, хамтран ажилласан байна.</p>	<p>М.Очмаа Р.Цолмонгэрэл</p>	<p>урамшуулал олгосон. 2024 онд нийт 756,773,916 төгрөгийн урамшуулал олгосон байна. 100 хувь</p> <p>Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Авлигатай тэмцэх газар, тус дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтран Нийтийн хэв журмыг сахиулах зорилго бүхий 20 хорооны 96 олон нийтийн байцаагч нарт Шүүхийн иргэдийн Төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Авлигын шалтгаан нөхцөл, гарах хор уршиг, гэмт хэрэг зөрчилтэй холбоотой мэдээлэл, стрессийг удирдахуй зэрэг сэдвээр сургалт зохион байгуулсан.</p> <p>Авлигатай тэмцэх газартай хамтран Ерөнхий боловсролын 2, 16, 35, 58, МУ-ын Консерватори сургуулийн сурагчдын 400 гаруй эцэг эх, асран хамгаалагчдад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын шалтгаан нөхцөл, гарах хор уршиг сэдвээр сургалт нөлөөллийн ажлыг үе шаттайгаар 4 удаа зохион байгуулсан.</p> <p>Авлигатай тэмцэх газар, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газартай хамтран Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн тухай, Авлигын шалтгаан нөхцөл, гарах хор уршиг, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль, шүүх хуралдаанд оролцохын ач холбогдол, тэдгээрийн идэвхийг нэмэгдүүлэх нь сэдвээр дүүргийн 300 гаруй иргэдэд сургалт зохион байгууллаа. 100 хувь</p>
--	--	--	------------------------	--	----------------------------------	---

<p>2.3. Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах</p>	<p>- 2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол байдлаар тогтмол мэдээлэх; - Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээг авах; - Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх.</p>	<p>I-IV улиралд</p>	<p>2024 оны хөрөнгө оруулалтын ажлуудын талаарх мэдээллийг олон нийтэд ил тод хүргэсэн байна.</p>	<p>Б.Бат-Эрдэнэ Г.Энхтөр</p>	<p>Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Дүүргийн 2024 оны төсөв батлах тухай" 14/88 тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтаар хийгдэх 158 төсөл арга хэмжээний 139,780,867.9 мян.төгрөгний ажлын гүйцэтгэлийн мэдээ, Орон нутгийн хөгжлийн сангийн 7 төсөл арга хэмжээний 1,690,843.5 мян.төгрөгний гүйцэтгэлийн мэдээг шилэн дансны тухай хуульд заасны дагуу санхүүгийн ил тод байдлыг хангаж хуулийн хугацаанд цахим хуудсанд мэдээлсэн 100 хувь.</p>
<p>2.4. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших</p>	<p>- Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах; - Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших; - Иргэд, олон нийтээс Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх.</p>	<p>I-IV улиралд</p>	<p>Ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, гарсан үр дүнд үндэслэн арга хэмжээ зохион байгуулсан байна.</p>	<p>Д.Чимэддулам</p>	<p>2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар Засаг даргын Тамгын газрын болон хороодын Засаг даргын ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой болон хороодын Засаг дарга нар, албан хаагчидтай холбоотой 19 өргөдөл гомдол ирснийг шалган тогтоож, 4 албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн. 2024 оны 04 дүгээр сарын 24, 25, 11 дүгээр сарын 14, 25-ны өдрүүдэд "Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн танилцуулга, асуудал шийдвэрлэх арга зам" сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулж, 100 албан хаагчийг хамруулсан. Мөн байгууллагын ёс зүйн дэд хорооны эрх, үүргийн талаар нэмэлт мэдээлэл өгч, албан хаагчдад тулгарч буй асуудлыг хуулийн дагуу хэрхэн шийдвэрлэх талаар кейс ажиллаж, харилцан туршлага хуваалцсан. 2024 онд албан хаагчийн ёс зүй, үйл ажиллагаатай холбоотой иргэдээс ирүүлсэн 22 гомдолд</p>

<p>болон төрийн албаны зөвлөлөөс байгуулагд3. Ашлиг сонирхлын зөрчил шалтгаан, арилгуулах хэмжээ авах</p>	<p>3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах тухайн цахимаар үүсгэх иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, арга хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>- Нэвтрүүлсэн үйлчилгээний хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах; - Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх; -Хэрэгжилтийг тайлагнах.</p>	<p>I-IV улиралд</p>	<p>Иргэд, олон нийтээс санал асуулга авч, үр дүнг үндэслэн арга хэмжээ авсан байна.</p>	<p>Бүх хэлтэс, тасаг</p>	<p>хяналт шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн. 90 хувь Төрийн үйлчилгээний мэдээллийг төвлөрсөн удирдлагатай Онлайн бизнес төвийн slaabaatar.mn платформоор дамжуулан 2000 гаруй худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, магадлан шалгах, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг 18 удаа хуралдаж, дүүргийн Засаг даргын захирамжаар худалдааны 168, хоол үйлдвэрлэлийн 172, нийт 340 ААН-д тусгай зөвшөөрөл олгож, холбогдох мэдээллийг sbd.gov.mn дүүргийн сайтад байршуулсан. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тамхи худалдах зөвшөөрлийн хүсэлтийг e-business.mn, emongolia.mn цахим сайтуудаар хүлээн авч, ДЗД-ын 9 удаагийн захирамжаар 23 ААН, иргэнд зөвшөөрөл олгож, sbd.gov.mn, license.mn цахим хуудаст байршуулан, ил тод мэдээлэн ажиллаж байна. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч 75 ААН, иргэний хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хорооны License.fgc.mn бүртгэлийн сайтаар хүлээн авч, ДЗД-ын 6 удаагийн захирамжаар 54 ААН, 2 иргэнд бүртгэлийн гэрчилгээ олгож, цахим сайтад байршуулсан. 100 хувь</p>
<p>3.2. Байгууллагын дотоод хяналтын механизмийг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга</p>	<p>- Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй гомдол, мэдээллийг</p>	<p>I-IV улиралд</p>	<p>1-2 арга хэмжээ зохион байгуулсан байна.</p>	<p>ХШУХ, Ёс зүйн дэд хороо</p>	<p>Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан сургалт, соён гэгээрэл,</p>	

	<p>хэмжээг хэрэгжүүлэх;</p>	<p>Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших;  - Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлолт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх;  - Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх;</p>			<p>урьдчилан сэргийлэх ажиллагааны хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 24, 25, 11 дүгээр сарын 14, 25-ны өдрүүдэд "Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн танилцуулга, асуудал шийдвэрлэх арга зам" сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулж, 100 албан хаагчийг хамруулсан. Мөн байгууллагын ёс зүйн дэд хорооны эрх, үүргийн талаар нэмэлт мэдээлэл өгч, албан хаагчдад тулгарч буй асуудлыг хуулийн дагуу хэрхэн шийдвэрлэх талаар кейс ажиллаж, харилцан туршлага хуваалцсан.  Сүхбаатар дүүрэг дэх төрийн 20 байгууллагын 700 гаруй албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн талаар 6 удаагийн танилцуулга, мэдээллийг 2024 оны 11 дүгээр сарын 12,15, 16,22,27,29-ний өдрүүдэд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооноос зохион байгууллаа.  90 хувь</p>
<p>3.3. Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлолт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>- Төлөвлөгөөний 1.1-3.2 дахь хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давцахгүй байх;  - Үйл Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээний онцлолт тохируулан зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх;  - Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх;  - Үйлчилгээ авдаг, хамтарч ажилладаг, зорилтот бүлэгт урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга</p>	<p>I-IV улиралд</p>	<p>1-2 арга хэмжээ зохион байгуулсан байна.</p>	<p>Бүх хэлтэс, тасаг</p> <p>ХХААХҮСайдын 2023 оны "Хяналтын хуудас батлах тухай" А/540 дугаар тушаал, НЗД-ын 2023 оны А/1116, 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/219 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын 2024 оны Сogтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, магадлан шалгах, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай А/90 дүгээр захирамжуудын хүрээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлсэн 630 ААН-ийн 400 гаруй ажлын байранд гүйцэтгэлийн хяналт хийж, тусгай зөвшөөрөл олгох саналыг Ажлын</p>	

		<p>хэмжээ, хийсэн өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл хүргэсэн байх.</p>			<p>хэсгийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/2-19 дүгээр захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн Сogтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, магадлан шалгах, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай А/90 дүгээр захирамжаар байгуулагдсан дүүргийн Ажлын хэсэг нийт 18 удаа хуралдаж, дүүргийн Засаг даргын захирамжаар 340 ААН-д согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгож, захирамжуудыг дүүргийн sbd.gov.mn цахим хуудаст байршуулан, зөвшөөрлийн талаарх тоон мэдээллийг УБЗАА-ны ХХҮГ-т улирал тутамд хүргүүлэн ажиллаж байна. 100 хувь</p>
	<p>3.4. Нутаг дэвсгэрийн харъяа байгууллага болон өөрийн удирдлагаас гаргаж байгаа тусаал, шийдвэрийн үндэслэл, хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ажил зохион байгуулах.</p>	<p>-Шийдвэрийн үндэслэл хуульд нийцсэн байх; -Хяналт шалгалтын ажил зохион байгуулж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан байх.</p>	<p>I-IV улиралд</p>	<p>Хяналт шалгалтын ажлыг 1 удаа зохион байгуулсан байна.</p>	<p>П.Булганмаа</p> <p>2024 онд Засаг даргын Тамгын газраас бусад аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан 815 гэрээг Иргэний хууль болон бусад хууль, эрх зүйн актад нийцүүлэн хянасан. Төрийн байгууллага хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт Авлигын эсрэг хуульд заасан авлигаас урьдчилан сэргийлэх заалтуудыг тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны А/450 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг дүүрэг дэх 5 сургууль, 12 цэцэрлэгт Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журам</p>

						<p>удирдлагаас гаргасан тушаал, шийдвэр хуульд нийцсэн эсэх, төрийн албан хаагч гэмт хэрэг үйлдэх, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор зөвлөмжийг хүргүүлэн биелэлтийг хангах үүрэг даалгавар өгсөн.</p> <p>100 хувь</p>
<p>3.5.Худалдан авах ажиллагааг сайжруулах ажиглалээр ажиг зохион байгуулах.</p>	<p>-Үнэлгээний гишүүдийг ажил зохион байгуулсан байх; -Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн ажил зохион байгуулсан байх.</p>	<p>I-IV улиралд</p>	<p>Сургалт зохион байгуулсан байна.</p>	<p>ХААА</p>	<p>Үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн. Худалдан авах ажиллагааг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн 1 видео контент бүтээсэн. Видео контентыг 2024 оны 7 дугаар сард байгууллагын албан ёсны вэб хуудас болон фэйсбүүк хуудсанд байршуулж олон нийтэд түгээхээр төлөвлөж байна.</p> <p>90 хувь</p>	

Биелэлтийн дундаж 95,4

ХЯНАСАН:  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

НЭГТГЭСЭН:  
ХҮНИЙ НӨӨЦ, ЁС ЗҮЙ, ХӨРӨНГӨ ОРЛОГЫН  
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Ө.ЭНХБАЯР

М.ОЧМАА